



МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЕБСУРГУУЛЬ

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273463

Шинжээч Ц.Хишигжаргал
Утас: 70273204
И-мэйл khj_616@yahoo.com

Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Танилцуулга 4
- Санхүүгийн дотоод хяналт 4-8
- Гол шийдлүүд 9
- Залруулаагүй алдаа... 9
- Тайлбар мэдүүлгийн захидал.... 9
- Аудитын санал дүгнэлт..... 10

Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний 2012 оны Санхүүгийн Тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний 2012 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мөнгөнморьт сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:** Батсүмбэр

- ✓ Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулвал:

Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

- ✓ Авлагаар тусгах мөнгийг, Бараа материалын тайланд үлдэгдэлээр тусгасан байна.
- ✓ Мал ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан, уг ажлын явцыг буруу мэдээллэж тайлагнасан МЭҮТасгийн дарга Н.Төмөртуяад хариуцлага тооцох санал хүргүүлэв.
- ✓ ЕБСургуулийн дотуур байрны инженер геологийн судалгааны ажлын зардал 2077.1 мянган төгрөгийг, уг барилгын төсөвт тусгуулж, ЕБСургуулиас буцаан авах акт бичив.
- ✓ Данс бүртгэлд тусгаагүй 675.2 мянган төгрөгийг ЗДТГазраар төлүүлж аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.

ЕМ, Санхүүгийн албанаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн хөрөнгө бэлтгэж тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар акт, албан

шаардлага бичиж тус тайланд
хязгаарлалттай санал дүгнэлт гаргахаар
Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа
Ерөнхий Аудитор 2013.03.28-ны өдөр
санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч
Д.Оюунчимэг нар бидэнтэй хамтран
ажиллаж бидний ажилд дэмжлэг болж
байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2013.03.28

Танилцуулга

1. Бид Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний 2012 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Сумын удирдлагуудад аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний удирдлагууд тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2012 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Мөнгөнморьт сумын ЗДТГазрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Мөнгөнморьт сумын НЕҮйлчилгээний удирдлагад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Мөнгөнморьт сумын НЕҮ-ний удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1.Санхүүгийн дотоод хяналт шалгалтын талаар

МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасан байдаг

Дотоод хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа талаар шалгахад сумын Засаг даргын 2011.02.28-ний өдрийн 29 тоот захирамжаар сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг Төрийн сангийн төлөөлөгчөөр ахлуулан 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байна.

Тус баг нь хийх хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөө гарган батлуулсан ба 1,2-р улиралын санхүүгийн баримтанд анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгийн тооллого тооцоо бодолтыг шалгаж ня-бо нарын ажлыг дүгнэж ажилласан гэх боловч энэ тухай тайлан байхгүй байна.

Жилийн эцэст дотоод хяналтын шалгалт хийгдсэн тайлан авчраагүй ба хяналт шалгалт хийсэн тухай тайланг тухай бүрд нь бичиж тайлан дүнг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хугацаатай үүрэг өгч биелэлтийг шалган ажиллах хэрэгтэй байна. Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллахыг дахин зөвлөж байна.

2. Орлого санхүүжилтийн талаар

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого, урсгал санхүүжилт 376858.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 392.3 мянган төгрөг, шилжиж ирсэн бараа материал 4310.3 мянган төгрөг, УТХОруулалтаар хийгдсэн их засвар ажлыг капиталжуулсаны орлого 86896.9 мянган төгрөгийн санхүүжилтын орлого тайлагнасан байна. Мөнгөн гүйлгээний үйл ажиллагааны мөнгөн орлого урсгал санхүүжилт 376858.4 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 392.3 мянган төгрөг нийт 377250.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Үндсэн бус үйл ажиллагаанаас орох орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ЕБСургуулийн 2013 оны урсгал зардлын төсвийг 378582.6 мянган төгрөгөөр төсвөөс санхүүжих, 120.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр нийт 378702.6 мянган төгрөгөөр баталж сар бүрийн төсвийн хуваарийг гаргасан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 377250.6 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 1451.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Үндсэн үйл бус ажиллагааны орлого 120.0 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 392.3 мянган төгрөгийн орлого оруулсан байна. Уг орлого нь багш ажилчдын байрны түрээсийн орлого ба тайлант онд 60.0 мянган төгрөгийн орлого дутуу байгааг нөхөн төлүүлэхээр акт бичив.

3.Үндсэн хөрөнгө

Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 487861.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 555219.5 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад тохирч байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр ном 360.0 мянган төгрөг, барилга байгууламж их засвараас 86656.3 мянган төгрөг, шилжиж ирсэн тоног төхөөрөмж 715.0 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 2420.3 мянган төгрөг, ном 1175.0 мянган төгрөг нийт 90966.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн дүн нэмэгдсэн ба атклаж хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй байна. Хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсест тооллого хийсэн бүртгэлтэй тулган шалгахад тооллогын бүртгэл болон тооцоо бодсон тухай комисс гарын үсэг зурж албажуулсан байна.

4.Бараа материал.

Санхүүгийн байдлын тайлангаарх бараа материалын эхний болон эцсийн үлдэгдэлийн дүнг, Бараа материалын тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад тус бүр тохирч байна. Бараа материалын тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн орлогын дүн 43893.7 мянган төгрөг байна.

- Түлш халаалтын зардлыг бараа материалын тайлангаас түүвэрлэн үзэхэд тус байгууллага нь тайлант онд нийт 259.5 м3 түлээний мод буюу 4752.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Сургуулийн ажилчид байгууллагын хэрэгцээнд зориулан 50 м3 түлээний мод бэлтгэх гоожин 1 м3 нь 4250 төгрөг нийт 212.5 мянган төгрөг тушаасан байна. Гэвч уг түлээний модыг 1 м3-ыг нь 18000 мянган төгрөгөөр үнэлэн мөнгийг бэлтгэн нийлүүлэгчдын дансаар дамжуулан гаргасан байна. Мөн уг түлээний модыг бэлтгэхийн тулд хоолны зардалд гэж 420.0 мянган төгрөгийг

- төсөвөөс гаргасан байна. Зүй нь 50 м3 түлээний модыг гоожингийн үнээр орлогодож төсвийг хэмнэх ёстой байтал бэлтгэн нийлүүлэгчдээс мод авдаг үнэ болох 18000 төгрөгөөр орлогод авсан нь ажилчдын хүчээр түлээний мод бэлтгэх ажил ямарч ач холбогдолгүй болсоныг нотолж байна. Иймээс хоолны үнэ болох 420.0 мянган төгрөг болон модны үнийн зөрүү 687.5 мянган төгрөг нийт 1107.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт бичив.
- Тус байгууллага нь шатахууны зардалд 1204.0 мянган төгрөг батлагдсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1203.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1263.5 мянган төгрөг гэж зөрүүтэй тайлагнагдсан байна. Зарцуулсан шатхуун ба гүйцэтгэсэн ажлыг шалгахад батлагдсан маршрут байхгүй, замын хуудас бичиж шатахуун зарцуулалтанд хяналт тавидаггүй, жолоочийн тооцоог боддоггүй, ажил гүйцэтгэсэн тухай хянаж баталгаажуулсан анхан шатны баримтууд хангалтгүй байна.
 - Дотуур байрны хүнсний материалын зардалд 28096.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 24674.2 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнасан ба 3421.9 мянган төгрөг хэмнэсэнийг төсөвт төвлөрүүлсэн байна. Хүнсний материалын зарцуулалтыг бараа материалын тайлантай тулгаж үзэхэд дотуур байрны хүүхдийн тоогоор 23205.1 мянган төгрөгийн зардал гарсан байхад үр дүнгийн тайлангаар 24674.2 мянган төгрөгийн зардал тусгасан ба 1469.1 мянган төгрөгийг зардалд илүү тусгасан байгаа нь өмнөх аудитын актын төлбөр болох 1905.0 мянган төгрөгийг хоолны зардлаас гаргасан байна. Мөн НБББодлогын өөрчлөлтийн бичиг баримтын үнэ 355.0 төгрөгийг хоолны зардалаас гаргасан байна.
 - Үдийн цай хөтөлбөрийн хэмжээнд 13065.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 12016.3 мянган төгрөг зарцуулсан байна. Бараа материалын тайлангаас тулган үзэхэд хүүхдийн тоогоор 9782.7 мянган төгрөгийн зардал гарсан байхад үр дүнгийн тайланд 12835.9 мянган төгрөгөөр тусгасан ба 3053.2 мянган төгрөгийг зардалд илүү тусгасан байна. Энэ нь өмнөх аудитын актын төлбөр 3044.0 мянган төгрөг үдийн цайны зардлаас төлсөн байна.
 - Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй /фэнг-шүй, далд ертөнц гэх мэт/ сонин хэвлэлийг захиалж 35.5 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байгууллагын удирдлагуудаар төлүүлэх төлбөрийн акт бичив.

Бараа материалын тайлангийн тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зохих журмын дагуу хийддэггүй, бараа материалын шаардах хуудсыг бүрэн бөглөдөггүй, бараа материал орлого авсан дүнгээр нь нэг дор зарлага бичиж гаргаж байна. Складаас гарч байгаа бүх төрлийн бараа материалыг шаардах хуудсаар олгодог боловч дугаарлагдаагүй, зөвшөөрсөн, хүлээлгэн өгсөн болон авсан хүний гарын үсэг бүрэн зурагдаагүй, зарлагын баримтанд хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан хүний гарын үсэг огт зурагдаагүй падааныг нэг дор бөөн бичиж баримтанд хавсрагадаг байна.

5.Цалингийн талаар

Цалингийн программаас Excel файлаар хөрвүүлэн 1-12 сарын цалингийн цэсийг нэгтгэн шалгахад нийт 229279.6 мянган төгрөг бодогдож харилцахын гүйлгээгээр ажилчдын цалинд 229681.3 мянган төгрөг шилжсэн ба 401.6 мянган төгрөгийн зөрүүтэй. Энэ нь ажилчдад олгосон листны мөнгө байна.

Цалингаас ХАОАТатвар 17709.8 мянган төгрөг, нийгмийн даатгалд 22927.9 мянган төгрөг цалингаас суутгасан мөн байгууллагаас НДШимтгэлд 25220.7 мянган төгрөг

тооцож шилжүүлсэн нь Мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан дүнтэй тохирч байна. Мөн Скайтель ХХК-иас ажилчдын авсан утасны үнийг суутган авч шилжүүлэх гэрээ хийсэн ба 100.0 төгрөгийг ажилчдаас суутган авсан боловч Скайтель ХХК-д шилжүүлээгүй, өглөг үүсгээгүй байна.

Багш нарт Авьяас хөтөлбөрийн хүрээнд 2253.4 мянган төгрөгийг олгосон ба 2013 оны 9-р саруудад олгосон 609.3 мянган төгрөг нь дугуйлан , секц ажиллуулсан гэх үндэслэлгүй байгаа тул дээрх 609.3 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт бичив. Цалингийн карт хөтөлсөн байдлыг шалгахад хүн тус бүрт карт хөтөлдөггүй, цалингийн цэсэнд гарын үсэг бүрэн зурагдаагүй байна. Нийт орон тоо 47, дарга 1, гүйцэтгэх ажилтан 46 хүний бүрэлдэхүүн ажилласан байна. 2012 оны Засгийн газрын 78-р тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлал, сүлжээний дагуу цалинг зөв тогтоосон байна.

6.Бараа үйлчилгээний зардал

Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 104648.2 мянган төгрөг, ТГТайлангаар 103014.3 мянган төгрөгөөр тайлагнагдсан 1633.9 мянган төгрөг хэмнэсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Бараа, үйлчилгээний зардалд төвлөрүүлэх шилжүүлэг 3723.7 мянган төгрөгийг оруулж тусгасан байна.Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Бараа үйлчилгээний нийт зардал нь 1633.9 мянган төгрөгөөр хэмэгдсэн байна. Үүнд тогтмол зардлаас 922.7 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 216.9 мянган төгрөг, шуудан холбоо болон ном хэвлэлээс 19.5 мянган төгрөг хэмнэсэн гэж тайлагнасан байна. Хэдийгээр зардал хэмнэгдсэн боловч хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлаас шатахууны зардалд, түлш халаалтын зардлаас шатахууны зардалд гэх мэт зарим зардлуудыг гүйлгэн зарцуулсан байна. Төсвийн төлөвлөлтийг бодитой хийж зардал хооронд нь гүйлгэн зарцуулахгүй байхад анхаарч ажиллах

Бараа материалын урсгал зардалуудад түүвэрлэн шалгалт хийж, журналуудыг сортлож үзэхэд:

- Гэрэл цахилгааны зардал 3946.8 мянган төгрөг төсөвлөгдсөн ба Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3944.6 мянган төгрөг, Мөнгөн гүйлгээний тайлангаар 3946.8 мянган төгрөг зарцуулсан гэж зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Тээвэр шатахууны зардалд 1204.0 мянган төгрөг батлагдаж Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1203.7 мянган төгрөг тайлагнагдсан Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 1263.0 мянган төгрөг гэж зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Түлш халаалтын зардалд 50644.8 мянган төгрөг төсөвлөсөнөөс гүйцэтгэлээр 49722.0 мянган төгрөг зарцуулан 922.7 мянган төгрөг хэмнэсэн гэх боловч бодит байдал дээр халаалтын зардлаас цахилгааны зардалд гүйлгэн зарцуулдаг байна. Тус компаниас нийт 42700.6 мянган төгрөгийн ажил үйлчилгээг худалдан авахдаа тендер зарлаж шалгаруулаагүй байна. Энэ нь сургуулийн халаалтыг хариуцан ажилладаг Тэнүүн зоргол ХХК нь шаардагдах түвшинд хүртэл халаалтыг өгдөггүйгээс өрөөнүүдэд цахилгаан тенг залгаж ажиллуулдагтай холбоотой байна. Мөн тус компани нь Багануурын уурхайд ойрхон байдаг боловч уурын зуухандаа мод түлж байгаа нь Байгаль орчин, ой модыг хамгаалах, галын түлээнд мод хэрэглэхийг хориглох, галын түлээнд хэрэглэх модны хэмжээг тогтоох зэрэг төр засаг, орон нутгийн бодлого шийдвэрт нийцэхгүй үйл ажиллагааг явуулдаг байна. Иймээс Тэнүүн зоргол ХХК-тай хийсэн гэрээг нягталж, халаалтын түвшин болон

талбайн хэмжээг дахин тооцож гэрээнд тодорхой тусгах, үр дүнг тооцож гүйцэтгэлээр нь дүгнэж байх шаардлагатай байна.

Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журнал, ТС-гийн хуулга, ЕД, ЕЖ, өглөг авлагын дэлгэрэнгүй журнал, АШБаримтыг ашиглан шалгав. Санхүүгийн тайлангаар бараа үйлчилгээний урсгал зардал нийт дүнгээрээ хэмнэлттэй боловч зардлын хооронд гүйлгэн зарцуулсан байна.

7.Мөнгөн хөрөнгө

Кассаар дамжуулан бэлэн мөнгөөр байгууллага, иргэдээс худалдан авсан бараа материалын үнээс ХХОАТатварыг 10%-иар тооцон суутгаж татварын байгуулагад шилжүүлсэн байна. Харилцах дансны гүйлгээг шалгахад Өнөр дэлгэрэх тулга ХХК-тай хүнсний болон бараа материалыг бэлтгэн нийлүүлэх гэрээ хийж нэхэмжлэлийн дагуу мөнгийг шижүүлдэг байна. Төрийн сан дахь харилцах дансаар болон байгууллагын мөнгөн кассаар нийт 386048.9 мянган төгрөгийн санхүүжилт, болон бусад орлогыг төвлөрүүлж үйл ажиллагааны холбогдох зардалд зарцуулан 3723.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу байрны түрээсийн орлого 375.0 мянган төгрөгийг харилцах дансаар дамжуулан төвлөрүүлсэн байна.

8.Авлага ,өглөгийн талаар

2013 оны эхэнд авлага өглөгийн тооцоогүй гэж тайланд тусгасан байна. Авлага, өглөгийг журналаас тулган үзэхэд байгууллага хувь хүмүүстэй 56586.6 мянган төгрөгийн авлага үүсгэж 56586.6 мянган төгрөгийг барагдуулсан байна. Мөн өглөгийн дансаар цалин, НДШ, ХАОАТатвар нийт 296146.2 мянган төгрөг, бараа үйлчилгээнд 69980.6 мянган төгрөг нийт 366126.8 мянган төгрөгийн өглөг тооцоолж барагдуулсан байна.

Тайлант онд Скайтель ХХК-иас 14-н хүн 1770.0 мянган төгрөгийн үнэ бүхий гар утас авч цалингаас суутгуулан төлөхөөр гэрээ хийсэн ба цалингаас нийт 1650.0 мянган төгрөг суутгасан боловч Скайтель ХХК-д 1550.0 мянган төгрөг шилүүлэн 100.0 мянган төгрөгийн өглөг үүссэнийг данс бүртгэлд тусгаагүй байна. Дээрх 100.0 мянган төгрөгийг байгууллагын нягтлан бодогчоор төлөөлөхээр төлбөрийн акт бичив.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн. Эдгээр асуудлуудыг ААГ болон Мөнгөнморьт сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын Газар аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч 71.5 сая төгрөгийг аудитын явцад залруулсан болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтнаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

8. Аймгийн Аудитын газраас тус тайланд дээрх хөрөнгө бэлтгэж тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар акт, албан шаардлага бичиж, хязгаарлалттай санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2013.03.18